



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2026.06.08 № 33

Газрын тос боловсруулах  
үйлдвэрийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна.

1.Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн улсын төсөв, дотоодын банк, Эрдэнэс Монгол нэгдэл болон Энэтхэгийн Эксим банк, бусад гадаад зээлээр авсан нийт хөрөнгө, түүний зарцуулалтын талаарх мэдээлэл;

2.Газрын тос боловсруулах үйлдвэрийн нийт бүтээн байгуулалт 2026 оны эхний хагас жилийн байдлаар хэдэн хувьтай, үүнээс үйлдвэрлэлийн үндсэн технологийн ба дэд бүтцийн барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцын талаарх мэдээлэл;

3.Тамсагийн сав газраас нефть дамжуулах хоолой татах ажлын гүйцэтгэлийн явц болон үйлдвэрийг түүхий нефтээр тасралтгүй хангах бусад эх үүсвэрийн талаарх мэдээлэл.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



С.ГАНБААТАР

2026000095